

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ...
тоот тогтоолын хавсралт*

РАДИО РЕЛЕЙНД АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү баримт бичиг нь Дэлхийн радиогийн их хурлаас баталсан Олон улсын радио давтамжийн дүрэм болон Монгол улсын “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийн заалтуудыг тус тус үндэслэн радио релейний станцад ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, радио давтамжийг үр дүнтэй ашиглах техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлоход оршино.

2. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

2.1 Энэхүү баримт бичиг нь зөвхөн утасгүй холбооны суурин радио релейнд ашиглагдах радио давтамжийн зурвасын хуваарилалт, түүний техникийн нөхцөл, шаардлагыг агуулах ба техникийн үзүүлэлтүүд, тоног төхөөрөмжийн бүтэц болон бусад олон талын техникийн үзүүлэлт агуулагдаагүй болно.

2.2 Хуваарилалтад Олон улсын радио давтамжийн дүрэмд тодорхойлогдсон дараах техникийн нөхцөл, шаардлагуудыг тусган авч үзнэ. Үүнд:

2.2.1 “Хөдөлгөөнт бус үйлчилгээ” гэж тодорхой хөдөлгөөнгүй суурин байх радио станцуудын хоорондох радио холбоо;

2.2.2 “Радио релей” гэж радио станцуудын хоорондох нэвтрүүлэх, хүлээн авах хоёр талт радио холбооны систем;

2.2.3 “Бага, дунд, их багтаамжит радио релей” гэж радио давтамжийн нарийн болон өргөн зурвастай зөөгч дохиог ашиглах радио холбоо.

2.3 Утасгүй холбооны суурин үйлчилгээний радио релейний системд ашиглагдах нийт радио давтамжийн зурвасын хуваарилалтыг давтамжийн зурвас тус бүрээр Үндэсний радио давтамжийн хуваарийн хүснэгтийн өгөгдөл болон Олон улсын цахилгаан холбооны байгууллагын ITU-R F серийн зөвлөмжүүдэд тусгасан зурвасын өргөнтэйгөөр суваг үүсгэн ашиглах ба ашиглалтын шаардлагаар хуваарилагдсан сувгуудыг нэгтгэн хуваарилах нөхцөлийг хангана. Үүнд:

2.3.1 Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлогдсон радио релейний станцад ашиглах нийт радио давтамжийн зурвасын хуваарилалт хавсралт 1;

2.3.2 Радио давтамжийн 5925-6425 МГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 2;

2.3.3 Радио давтамжийн 7125-7725 МГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 3;

2.3.4 Радио давтамжийн 7725-8500 МГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 4;

2.3.5 Радио давтамжийн 10.0-10.68 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 5;

2.3.6 Радио давтамжийн 10.7-11.7 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах

- радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 6;
- 2.3.7 Радио давтамжийн 12.75-13.25 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 7;
- 2.3.8 Радио давтамжийн 14.4-15.35 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 8;
- 2.3.9 Радио давтамжийн 17.7-19.7 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 9;
- 2.3.10 Радио давтамжийн 21.2-23.6 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 10;
- 2.3.11 Радио давтамжийн 31.0-31.3 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 11;
- 2.3.12 Радио давтамжийн 31.8-33.4 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 12;
- 2.3.13 Радио давтамжийн 36.0-40.5 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 13;
- 2.3.14 Радио давтамжийн 40.5-43.5 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 14;
- 2.3.15 Радио давтамжийн 51.4-52.6 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 15;
- 2.3.16 Радио давтамжийн 55.78-66.0 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 16;
- 2.3.17 Радио давтамжийн 71.0-76.0/81.0-86.0 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 17;
- 2.3.18 Радио давтамжийн 92.0-95.0 ГГц-ийн зурваст ажиллах шууд харагдах радио релейний системийн сувгийн хуваарилалт хавсралт 18.

3 ХЯНАЛТ БА БУСАД

- 3.1 Зохицуулах хороо нь радио давтамжийн зурвасын ашиглалтын байдалд холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж хэрэгжилтийг хангана.
- 3.2 Зохицуулах хороо нь холбогдох хууль тогтоомж болон төрөөс баримтлах бодлого, техник технологийн дэвшил, үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт, дахин төлөвлөлтөөс хамааруулан энэхүү баримт бичигт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулна.

-----oOo-----

“Радио релейнд ашиглах радио
давтамжийн зурвасын хуваарилалт,
техникийн нөхцөл, шаардлага”-ын
1 дүгээр хавсралт

РАДИО РЕЛЕЙНД АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Давтамжийн зурвас (МГц)	Хуваалтын технологи	Хуваарилах сувгийн өргөн (МГц)
1	5925 - 6425	FDD	20 / 29.65
2	7125 - 7725	FDD	7 / 14 / 28
3	7725 - 8500	FDD	7 / 10 / 14 / 20 / 28
4	10000 - 10680	FDD	7 / 14 / 28 / 56
5	10700 - 11700	FDD	10 / 20 / 40 / 80
6	12750 - 13250	FDD	3.5 / 7 / 14 / 28 / 56
7	14400 - 15350	FDD	7 / 14 / 28 / 56
8	17700 - 19700	FDD	27.5 / 55 / 110 / 220
9	21200 - 23600	FDD	7 / 14 / 28 / 56
10	31000 - 31300	FDD	7 / 14 / 28
11	31800 - 33400	FDD	7 / 14 / 28 / 56 / 112
12	36000 - 40500	FDD	7 / 14 / 28 / 56 / 112
13	40500 - 43500	FDD	7 / 14 / 28 / 56 / 112 / 224
14	51400 - 52600	FDD	7 / 14 / 28 / 56
15	55780 - 66000	FDD	7 / 14 / 28 / 56 / 112
		TDD	7 / 14 / 28 / 30 / 50 / 56
16	71000 - 76000 81000 - 86000	FDD/TDD	250 / 500
17	92000 - 95000	FDD/TDD	50 / 100 / 200

-----oOo-----